

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

8 дугаар сард Засаг даргын тамгын газрын 15 албан хаагч ээлжийн амралт авч амраад ажилдаа орсон.

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 3-ны өдрийн А/28 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдож Алтан дарь овооны 110 жилийн ойн баяр наадамд ажилласан. 2023 онд Тус сумаас Улсын аварга малчин 2 тодорсон ба намрын налгар цаг 8 дугаар сард мялаалга наадмын арга хэмжээг зохион байгуулж эрийн 3 наадам болон бусад тэмцээн уралдаан зохион байгуулсан.

Багийн иргэдийг мэдээ мэдээллээр хангах, эвлэлдэн нэгдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор жил бүр багийн өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн Тайлант оны хувьд 8 дугаар сарын 15-ны өдрөөс 24-ны өдрийн хооронд 5 багийн багийн өдөрлөгүүд зохион байгуулагдсан. Өдөрлөгийн арга хэмжээнд багийн иргэд бүлгийн зохион байгуулалтаараа оролцсон. Сумын эрүүл мэндийн төвөөс сургалт мэдээлэл, эрт илрүүлгийн үзлэг хийж 545 иргэн, 15-34 насны залуучуудыг ВС вирүсын шинжилгээнд 200 гаруу залуучуудыг хамруулсан байна. Мөн спортын 5 төрөлт тэмцээн, сайхан морьтон шалгаруулах тэмцээнүүд зохион байгуулагдсан.

8 дугаар сарын 11-24-ны өдрийн хооронд 5 багийн төвд хөдөөгийн гэр сувилал ажиллаж нийт 63 ахмад настан амарч сувилуулж эмчлүүлсэн.

1, 3 дугаар багийн өдөрлөг, 1,5 дугаар багийн ахмадын сувилалд амарч буй ахмадууд, өдөрлөгийн арга хэмжээнд хамрагдаж буй иргэдэд “Хөдөөгийн хөгжил”, хоршоололд нэгдэн орхын ач тус сэдэвт сургалтыг МУ-ын гавъяат эдийн засагч Авирмэд зохион байгуулж 170 гаруу иргэд хамрагдсан байна.

Бага насны хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх тухай Аймгийн Засаг даргын захирамийг 5 багийн өдөрлөгийн арга хэмжээнд оролцож буй иргэдэд танилцуулж гарын авлага тараах материал тарааж ажиллаа

Байгаль орчин , Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн чиглэлээр

Аймгийн засаг даргын 2023 оны А/490 тоот захирамжын дагуу Сумын Засаг даргын 8 сарын 9-ны А/129 захирамжаар Хурганы цэцэг өвчинөөс урьдчилан сэргийлэх вагцинжуулалт сумынм хэмжээнд хийгдэж байна. Энэ сарын байдлаар вагцинжуулалт ажил явагдаж байна.

ЗГ-ын 225 дугаар тогтоол, мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А/179 тоот тушаал, АЗД-ын А/495 тоот захирамжийн

дагуу Төл малд бруцеллёз өвчинөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг Сумын засаг даргын 8 дугаар сарын 21-ны өдрийн А/138 тоот захирамжаар сумын хэмжээнд зохион байгуулж байна.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

1. ЭМТөвд төрсөн эх – 3
Нийт төрсөн эх – 26
Нас баралт –12 / хавдар-4, бусад-8/
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 372
Ор хоног – 2430
Нийт үзлэг – 4161
Эрэгтэй – 1865
Эмэгтэй – 2296
Урьдчилан сэргийлэх үзлэг –1567
Идэвхитэй хяналт – 1248
Жирэмсний хяналт-36/25/70%
Амбулаторийн үзлэг –1158
Анхан – 471
Давтан – 687
Гэрийн дуудлага – 366
Халдварт өвчлөл – 2
Шинэ-2
Хуучин -0
Түргэн тусламжийн дуудлага – 398
Алсын дуудлага– 272
Осол гэмтлийн дуудлага – 11
Эрт илрүүлэг үзлэг
Хөхний өмөн – 870/505/63,1%
Умайн хүзүүний өмөн – 220/52/ 23.6%
Артерийн даралт ихдэлт – 940/760/80.8%
Чихрийн шижин – 1400/750/53.5%
2. Сургалт сурталчилгаа
Тараах материал-480
Цахим хуудас-480 төрлийн мэдээлэл байршуулж 15668 хүний хандалт
Танхимын сургалт -14 удаа 462 хүн хамруулсан,

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн Б/23 тоот захирамжаар Г.Саруулыг Сумын ЭМТөвийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж мөн өдрийн Б/24 тоот захирамжаар Г.Алтантуяаг ЭМТөвийн даргаар томилон ажиллуулж байна.

2023.08.01-нд Эрүүл мэндийн цогц үзлэг цахим сургалтанд ЭМТ-ийн Дарга М.Алтантуяа, Их эмч Цоггэрэл, бага эмч Б.Энхцэцэг,нар хамрагдсан.

“ХЕПАТИТАЙ ТЭМЦЭХ ӨДӨР” Гепатитын С,В Вирус ,халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэлтийн талаар амбулаторийн 15 үйлчлүүлэгчдэд сургалт мэдээлэл хийж гарын авлага тарааж зөвлөгөө өгч ажиллаа

2023 оны 08,11 нээс 5 багт Гэр сувилал гаргаж нийт 63 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмчилгээ сувилгаа, бариа засал дасгал хөдөлгөөн ,сургалт сурталчилгаа хийж мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Мөн 5 багийн өдөрлөг дээр үзлэг оношилгоо В,С Вирус ,Сахар,Дох,Тэмбүүгийн шинжилгээ хийж СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ХҮН БҮРТ АЯНЫ ХҮРЭЭНД 545 хүнд сургалт мэдээлэл өгч гарын авлага тарааж ажилласан.

СЭМХ -ноос Глобаль сангийн дэмжлэгтэй Монгол улсад ДОХ,Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх ,түүнийг эмчлэх үндэсний тотолцоог бэхжүүлэх, дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд 12 суманд эрүүл мэндийн цогц үзлэгийг 2023 оны 08.15 наас зохион байгуулагдсан, Сумын ЭМТ –д 2023 оны 08.15 зохион байгуулагдсан Үүнд: 200 иргэнд үзлэг шинжилгээ оношилгоо хийгдсэн. Шаардлагатай сорьц тээвэрлэх 12 хүний сорьцыг АНЭ-ийн лаборторит хүргэж ажилласан.

Эхийн сүүгээр хоололтыг дэмжих мэдээлэл сурталчилгааны 7 хоногт “Ажил олгогч та хөхүүл эхийг дэмжсэн орчин бүрдүүлж эхийн сүүгээр хоололтыг дэмжсэнээр ирээдүйн эрүүл монгол хүнийг бий болгоно ”уриа уриалга уриа гаргаж цахимаар мэдээлэл өгч 435 хандалт авч ажилласан.

Олон нийтэд түшиглэсэн Нялх,бага насны хүүхдийн хоололтын зөвлөгөө өгөх ур чадвар олгох сургалтанд 2023 оны 08 дугаар сарын 19-23 ны өдрүүдэд ЭМТ-ийн дарга М.Алтантуяа хамрагдсан

Гепатитгүй монголчууд төслийн хүрээнд эмч эмнэлгийн ажилчдад сургалт АЭМГ дээр зохион байгуулагдсан сургалтанд НЭМА Ж.Алтанчимэг,Бага эмч Ц.Туяа нар хамрагдсан.

Хүүхдийн товлолын вакцинжуулалт 08 сард 30 хүүхдэд хийгдсэн. вакцины болон хөхөөр хоололтын ач холбогдол, ягаан дэвтэр хөтлөлтын талаар ээжүүдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 8 дугаар сард:

- Ирсэн бичиг – 1
- Явсан бичиг – 0
 - Хариутай бичиг – 0
 - Хугацаандаа явсан бичиг – 0
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. Оюутан залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, төрөлх нутгаараа бахархах, эв нэгдлийг эрхэмлүүлэх зорилгоор Улсын тэргүүний Сүбаатар сумын Засаг даргын тамгын газартай хамтран "THE UNITY OF SUKHBAATAR" **оюутан залуучуудын уулзалт хэлэлцүүлэг**-ийг танхимаар зохион байгуулсан. Тус уулзалт хэлэлцүүлэгт 85 хүн хамрагдаж шинээр залуучуудын холбоо байгуулан, дарга тэргүүлэгч нараа сонгон, ажлын төлөвлөгөө боловсруулсан.

1.2. Оюутан залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, төрөлх нутгаараа бахархах, эв нэгдлийг эрхэмлүүлэх зорилгоор Улсын тэргүүний Сүбаатар сумын Засаг даргын тамгын газартай хамтран "THE UNITY OF SUKHBAATAR" **оюутан залуучуудын урлагийн наадам**-ыг танхимаар зохион байгуулсан. Урлагийн наадмын 2 өдрийн турш амжилттай зохион байгуулсан. Урлагийн наадам гоцлол дуу, гоцлол хөгжим гэсэн хоёр төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд 5 багийн 10 оюутан залуучууд хамрагдаж, шагналт байруудыг шалгаруулсан. Танхимаар 93 хүнд хүрсэн.

1.3. "THE UNITY OF SUKHBAATAR" оюутан залуучуудын **үдшийн шоу арга хэмжээ**-г 2 өдрийн турш зохион байгуулса. Шоу арга хэмжээнд Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” театрын залуу уран бүтээлчид болох А.Баярхүү, Ц.Бямбасүрэн, Д.Болортуяа нарыг урин авчирч, Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчидтай хамтран урлагийн тоглолтыг зохион байгуулж, тэмцээн уралдааны шагналуудыг гардуулсан. Задгай шоунд нийт 150 хүн хамрагдсан.

1.4. Монгол улсын аварга малчин Батдоржийн Ариунбаатар, Цогзолын Мөнхзул нарын цолны мялаалга наадмыг Сүхбаатар сумын Баянгол багийн Энгэр хулст хэмээх газарт нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Тус наадмын нээлтийн үйл ажиллагаанд Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” театрын морин хуурч ая зохиогч МУСТА Б.Тэгшжаргал, дуучин МУСТА Х.Амартайван, МУСТА Л.Батжаргал, дугуйлангийн сурагчид, Соёлын төвийн хамт олон оролцон нэг цагийн урлагийн тоглолтыг малчны хотонд зохион байгуулсан. Мөн бүтэн өдрийн турш тэмцээн уралдаан, урлаг соёлын үйл ажиллагаа, малчдад зориулан үдшийн шоу арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Аварга малчны наадмын соёл урлагийн үйл ажиллагаанд 10 уран бүтээлч хамрагдан 280 хүнд хүрсэн.

1.5. Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд Орлогч дарга, Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан ЛУВСАНГИЙН МИНЖЭЭ-гийн үр хүүхдүүд болох М.Сэргэлэнбат гэргий, ах дүү нарын хамт Үндэсний өв соёлоо эрхэмлэн дээдэлж сумынхаа Соёлын төвд урлагийн хувцасны хандив өргөлөө. Нийт гоцлол дуучны 5-н иж бүрдэл Монгол дээлийг хандивласан болно.

1.6. Сүхбаатар сумын **Хайлаастай багийн өдөрлөг**-ийг Д.Сүхбаатарын талбайд 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд дугуйлангийн сурагчид, ардын авъяастнуудын хамтарсан урлагийн тоглолтыг олон нийтэд толилуулсан. Соёл урлагийн үйл ажиллагааг нийт 103 хүнд хүргэсэн.

1.7. Монгол улсын аварга малчин Батболдын Сүхбаатар, Сүхбаатарын Болорчимэг нарын цолны мялаалга наадмыг Сүхбаатар сумын Хулгар багийн Үетийн ширээ хэмээх газарт нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Тус наадмын нээлтийн үйл ажиллагаанд Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” театрын морин хуурч Ариунболд, уртын дуучин МУСТА Ариунжаргал, МУСТА Л.Батжаргал, дугуйлангийн сурагчид, ахмад уран бүтээлчид, Соёлын төвийн хамт олон оролцон нэг цагийн урлагийн тоглолтыг малчны хотонд зохион байгуулсан. Мөн бүтэн өдрийн турш тэмцээн уралдаан, урлаг соёлын үйл ажиллагаа, малчдад зориулан үдшийн шоу арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Аварга малчны наадмын соёл урлагийн үйл ажиллагаанд 12 уран бүтээлч хамрагдан 280 хүнд хүрсэн.

1.8. Сүхбаатар сумын **Шинэ булаг багийн өдөрлөг**-ийг багийн төвд 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” театрын уран бүтээлч МУСТА А.Идэрзаяа, МУСТА О.Ганзориг, МУСТА Л.Батжаргал, дугуйлангийн сурагчид, ахмад уран бүтээлчид, Соёлын төвийн хамт олон оролцон нэг цагийн урлагийн тоглолтыг малчны хотонд зохион байгуулсан. Багийн өдөрлөгийн соёл урлагийн үйл ажиллагаанд 8 уран бүтээлч хамрагдан 195 хүнд хүрсэн.

1.9. Малчдад зориулсан бэлчээрийн тухай сургалт танхимаар зохион байгуулагдаж, 76 хүн хамрагдсан.

1.10. Сүхбаатар сумын **Ланз багийн өдөрлөг**-ийг багийн төвд 2023 оны 8 дугаар сарын 23-ны өдөр нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд Залуу дуучин Д.Дэлгэртуяа, Э.Гонгоржав, дугуйлангийн сурагчид, Соёлын төвийн хамт олон оролцон урлагийн тоглолтыг малчны хотонд зохион байгуулсан. Багийн өдөрлөгийн соёл урлагийн үйл ажиллагаанд 5 уран бүтээлч хамрагдан 178 хүнд хүрсэн.

1.11. Сүхбаатар сумын **Баянгол багийн өдөрлөг**-ийг багийн төвд 2023 оны 8 дугаар сарын 24-ний өдөр нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан. Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд Залуу дуучин Д.Дэлгэртуяа, Э.Гонгоржав, дугуйлангийн сурагчид, Соёлын төвийн хамт олон оролцон урлагийн тоглолтыг малчны хотонд

зохион байгуулсан. Багийн өдөрлөгийн соёл урлагийн үйл ажиллагаанд 5 уран бүтээлч хамрагдан 216 хүнд хүрсэн.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

2.1. Сүхбаатар аймгийн ИТХ-ын төлөөлөгч И.Батсүх **СОЁЛЫН ТӨВИЙН НОМЫН САНД** хувиасаа 300,000 төгрөгний 12 ширхэг орчин үеийн уран зохиолын номоор баяжилт хийж шинэ ном хандивлалаа.

2.2. Монгол улсын аварга малчин Батболдын Сүхбаатар, Сүхбаатарын Болорчимэг нарын цолны мялаалга наадамд Зөөврийн номын санг ажлуулсан. Нийт 43 хүнд 60 номоор үйлчилсэн болно.

2.3. Ланз багийн өдөрлөгийн үйл ажиллагааны үеэр зөөврийн номын санг ажлуулсан. Нийт 35 хүнд 55 номоор үйлчилсэн.

2.4. Баянгол багийн өдөрлөгийн үйл ажиллагааны үеэр зөөврийн номын санг ажлуулсан. Нийт 42 хүнд 50 номоор үйлчилсэн.

8-н сард 120 уншигчид 165 ном олгосон.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

3.1. Сүхбаатар сумын Орон нутаг судлах музейг зохиолч яруу найраг Х.Энхбат ирж үзэж сонирхсон сумын 100-н жилийн судалгааны материал дээр ажилласан. Хамрагсад 4.

ДӨРӨВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Соёлын төвийн бүжгийн дугуйлангийн охидын хамтлаг “Миний Монгол наадам” бүжгийг хоёр аварга малчны наадам, 2 багийн өдөрлөгт бүжиглэж олон нийтэд хүргэсэн.

4.2. Сүхбаатар сумын ЕБС-ийг 1971 онд төгсөгчдийн 35-н жилийн ойн уулзалтанд зориулсан үдшийн цэнгүүнийг танхимаар зохион байгуулсан.

ТАВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. Соёлын төвийн дарга 08 дугаар сарын 07-ны өдрөөс, номын санч, техникч нар 2023 оны 08 дугаар сарын 15-наас, дуу хөгжмийн багш 08 дугаар сарын 21-нээс тус тус ээлжийн амралтаа авсан. Бүжгийн багш, үйлчлэгч нар ажиллаж байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Зүүн бүсийн жишиг соёлын төв нь 2023 оны Наймдугаар сарын байдлаар **18** үйл ажиллагаа зохион байгуулж, танхимын

болон явуулын үйлчилгээгээр **1811** үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ, арга хэмжээг хүргэн ажилласан. Хамрагсадын тоо **49**

МЭДЭЭ ГАРГАСАН :

Дотоод ажилтан, Хууль, эрх зүйн мэргэжилтэн

/С.Ариунзаяа/

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/